



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар A/452

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 4 дүгээр
сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгдчийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

5. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,098,733 /таван сая ерэн найман мянга долоон зуун гучин гурван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасаг хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 4 дүгээр сургууль /А.Энхтуяа/-д зөвшөөрсүгэй.

6. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 4 дүгээр сургууль /А.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11...сарын 13... өдрийн 1/48 дүгээр тушаалын хавсралт

Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 4 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	ЭБХХХК-ын хурлын шийдвэр	
1	Сурах бичиг	2008-2017	2-11	ш	3324	-	5,098,733	-	-	Устгах	
Номын фонд								5,098,733	-	-	
Нийт								5,098,733	-	-	